**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2024/07/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | “Ашид баланс аудит” ХХК-ийн захирал Л.Майцэцэг<br>Утас: 99081568  Цахим хаяг: ashidbalance@gmail.com<br><br>Ахлах аудитор: Д.Алтанцэцэг<br>Утас: 99178619  Цахим хаяг: ashidbalance@gmail.com<br><br>Туслах аудитор:  Д.Сэрчинмаа<br>Утас: 99265037   Цахим хаяг: ashidbalance@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 394

танай ____________-ны №____________-т

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ЭЛЭГ СУДЛАЛЫН КЛИНИК
ТӨВИЙН ЗАХИРАЛ Х.ГҮРБАЗАР
ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг цахим и-баримтгүй шилжүүлж, бүртгэлд тусгасан, ажилтнуудад Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журамд заагаагүй хариуцлагын нэмэгдлийг сар бүр олгосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зэрэг нийт 3,000,981.1 мянган төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлан болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллагын сувилал эмчилгээний 2,833,050.0 мянган төгрөгийн барилга давхар бүртгэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Цаашид тус байгууллагын

талаар чиг үүрэг нь өөрчлөгдөх, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзлээ.

**Аудитын гол асуудал**

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн сувилал эмчилгээний барилга 2012 оноос хойш өнөөг хүртэл санхүүгийн тайланд давхар бүртгэлтэй байгаа бөгөөд өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар энэ алдааг залруулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласны гүйцэтгэлийг 92.7 хувьтай гэж үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **442,723,025.82** | **335,005,703.96** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **84,312,352.47** | **4,056,812.87** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **84,312,352.47** | **4,056,812.87** |
| **31210** | **Төгрөг** | **84,312,352.47** | **4,056,812.87** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 84,312,352.47 | 4,056,812.87 |
| **33** | **АВЛАГА** | **189,811.81** | **60,081,350.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 189,811.81 | - |
| **33500** | **Бусад авлага** | **-** | **60,081,350.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 60,081,350.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **358,220,861.54** | **270,867,541.09** |
| **35100** | **Түүхий эд материал** | **199,615,749.54** | **141,478,576.09** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 16,699,597.64 | 19,851,559.64 |
| 35130 | Эм боох материал | 182,916,151.90 | 121,260,316.45 |
| **35400** | **Хангамжийн материал** | **158,605,112.00** | **129,388,965.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,793,389.00 | 2,955,575.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,796,922.00 | 9,958,830.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,140,800.00 | 302,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,621,309.00 | 715,529.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,211,000.00 | 990,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,320,290.00 | 6,506,920.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 128,721,402.00 | 107,960,111.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,971,197,243.83** | **1,754,316,237.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,971,197,243.83** | **1,754,316,237.80** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,971,197,243.83** | **1,754,316,237.80** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,123,590,800.00 | 7,123,590,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (6,735,172,933.16) | (6,752,060,666.48) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 55,177,266.40 | 55,177,266.40 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (55,177,266.40) | (55,177,266.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,880,779,359.33 | 1,948,722,059.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (393,971,366.55) | (643,965,849.34) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 141,162,072.40 | 141,162,072.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,571,118.19) | (66,512,608.11) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,295,600.00 | 1,295,600.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (1,295,600.00) | (1,295,600.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,767,230.00 | 7,767,230.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,386,800.00) | (4,386,800.00) |
| 39301 | Программ хангамж | 980,000.00 | 980,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (980,000.00) | (980,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,413,920,269.65** | **2,089,321,941.76** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **384,019,301.49** | **1,475,919,174.90** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **384,019,301.49** | **1,475,919,174.90** |
| **41300** | **Өглөг** | **384,019,301.49** | **1,475,919,174.90** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 147,541,042.35 | 684,599,866.13 |

| | | | |
|---|---|---|---|
| **41360** | **Бусад өглөг** | **236,478,259.14** | **791,319,308.77** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 236,478,259.14 | 789,006,408.77 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 2,312,900.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,029,900,968.16** | **613,402,766.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,029,900,968.16** | **613,402,766.86** |
| **51100** | **Засгийн газрын оруулсан капитал** | **549,910,480.39** | **549,910,480.39** |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 549,910,480.39 | 549,910,480.39 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **454,802,664.63** | **(961,695,536.67)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 454,802,664.63 | 454,802,664.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (1,416,498,201.30) |
| **51300** | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **1,025,187,823.14** | **1,025,187,823.14** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,413,920,269.65** | **2,089,321,941.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **4,513,253,087.40** | **3,971,008,789.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **160,167,262.40** | **96,313,759.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **160,167,262.40** | **95,313,759.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **86,904,732.40** | **86,734,059.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 86,904,732.40 | 86,734,059.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 73,262,530.00 | 9,579,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,353,085,825.00** | **3,874,695,030.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **4,353,085,825.00** | **3,874,695,030.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,353,085,825.00 | 3,874,695,030.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,416,879,697.54** | **5,387,506,990.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,416,879,697.54** | **5,387,506,990.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,415,379,697.54** | **5,387,506,990.30** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,400,283,025.79** | **2,679,676,778.70** |
| 210101 | Үндсэн цалин | 1,331,630,645.32 | 1,613,336,608.96 |
| 210102 | Нэмэгдэл | 800,070,055.47 | 925,030,669.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 142,370,500.00 | 141,309,500.00 |
| 210104 | Урамшуулал | 126,211,825.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **299,045,293.63** | **331,091,342.05** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 208,394,839.78 | 229,153,768.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,517,037.57 | 27,384,907.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,240,669.87 | 23,976,886.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,210,980.04 | 4,490,904.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,681,766.37 | 46,084,874.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **540,050,215.12** | **558,278,290.72** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 95,650,726.28 | 153,235,404.71 |
| 210302 | Түлш, халаалт | 288,350,333.89 | 263,939,167.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 156,049,154.95 | 141,103,718.27 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **277,862,828.25** | **225,158,112.86** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,263,650.00 | 4,460,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,765,871.00 | 24,905,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 38,022,852.25 | 28,982,020.86 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 21,663,550.00 | 29,718,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 186,146,905.00 | 75,642,254.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 61,449,658.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,074,710,452.85** | **1,233,706,140.94** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 640,142,194.85 | 596,166,650.94 |
| 210502 | Хоол, хүнс | 434,568,258.00 | 637,539,490.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **566,364,160.80** | **29,042,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 160,000.00 | 350,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 566,204,160.80 | 28,692,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,344,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,344,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **37,153,659.00** | **45,230,619.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 6,300,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,567,935.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,915,000.00 | 14,268,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 23,148,024.00 | 24,212,619.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,622,700.00 | 450,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,900,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **218,566,062.10** | **285,323,706.03** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,241,000.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 214,325,062.10 | 284,823,706.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,500,000.00** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,500,000.00** | **-** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **(903,626,610.14)** | **(1,416,498,201.30)** |
| **4** | **НИЙТ ҮР ДҮН** | **(903,626,610.14)** | **(1,416,498,201.30)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **6,594,206,790.40** | **3,901,347,739.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **86,904,732.40** | **86,734,059.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **86,904,732.40** | **86,734,059.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **86,904,732.40** | **86,734,059.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 86,904,732.40 | 86,734,059.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,507,302,058.00** | **3,814,613,680.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **6,507,302,058.00** | **3,814,613,680.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 6,507,302,058.00 | 3,814,613,680.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,543,496,525.55** | **3,916,460,478.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,543,496,525.55** | **3,916,460,578.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,541,996,525.55** | **3,916,460,578.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,318,240,000.09** | **2,318,971,733.61** |
| 210101 | Үндсэн цалин | 1,206,795,718.26 | 1,313,138,520.70 |
| 210102 | Нэмэгдэл | 842,900,160.31 | 870,639,879.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 142,341,204.30 | 135,193,333.50 |
| 210104 | Урамшуулал | 126,202,917.22 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **241,674,310.39** | **154,547,751.55** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 192,049,134.89 | 125,411,237.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,443,429.69 | 8,069,760.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,543,063.69 | 6,323,808.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,299,403.35 | 1,303,958.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,339,278.77 | 13,438,986.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **526,457,215.92** | **480,613,691.59** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 95,650,726.28 | 105,849,665.90 |
| 210302 | Түлш, халаалт | 286,108,346.93 | 241,947,959.24 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 144,698,142.71 | 132,816,066.45 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **158,829,008.25** | **130,166,545.86** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,896,150.00 | 10,111,285.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,010,000.00 | 21,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 37,921,752.25 | 25,521,620.86 |
| 210404 | Ном, хэвлэл | 125,100.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 28,151,970.00 | 29,017,580.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 56,724,036.00 | 44,516,060.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,331,221,522.50** | **748,245,730.99** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 892,481,722.50 | 250,268,930.99 |
| 210502 | Хоол, хүнс | 422,263,000.00 | 497,976,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,476,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **914,011,909.40** | **135,022,825.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 189,612,640.00 | 65,142,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 724,399,269.40 | 69,880,125.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,235,600.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,235,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **42,085,959.00** | **13,535,000.00** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,567,935.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,915,000.00 | 12,268,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 23,148,024.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,560,000.00 | 450,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 9,895,000.00 | 817,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,241,000.00** | **500,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,241,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,500,000.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,500,000.00** | **-** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | - |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,050,710,264.85** | **(15,112,839.60)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **966,461,223.00** | **65,142,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **966,461,223.00** | **65,142,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **966,461,223.00** | **65,142,700.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 966,461,223.00 | 65,142,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(966,461,223.00)** | **(65,142,700.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **84,249,041.85** | **(80,255,539.60)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 63,310.62 | 84,312,352.47 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 84,312,352.47 | 4,056,812.87 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **549,910,480.39** | **1,025,187,823.14** | **1,358,429,274.77** | **2,933,527,578.30** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | **-** |
| Дахин илэрхийлэх үлдэгдэл | **549,910,480.39** | **1,025,187,823.14** | **1,358,429,274.77** | **2,933,527,578.30** |
| Тайлант үеийн үр дүн | | | (903,626,610.14) | **(903,626,610.14)** |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **549,910,480.39** | **1,025,187,823.14** | **454,802,664.63** | **2,029,900,968.16** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | **-** |
| Дахин илэрхийлэх үлдэгдэл | 549,910,480.39 | 1,025,187,823.14 | 454,802,664.63 | **2,029,900,968.16** |
| Тайлант үеийн үр дүн | | | (1,416,498,201.30) | **(1,416,498,201.30)** |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **549,910,480.39** | **1,025,187,823.14** | **(961,695,536.67)** | **613,402,766.86** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,783,143,000.00** | **3,981,603,278.60** | 1,801,539,721.40 | 68.8 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,783,143,000.00** | **3,981,603,278.60** | 1,801,539,721.40 | 68.8 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,780,443,000.00** | **3,981,603,278.60** | 1,798,839,721.40 | 68.9 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,175,000,000.00** | **2,318,971,733.61** | 856,028,266.39 | 73.0 |
| Үндсэн цалин | 2,031,698,500.00 | 1,313,138,520.70 | 718,559,979.30 | 64.6 |
| Нэмэгдэл | 768,301,500.00 | 870,639,879.41 | (102,338,379.41) | 113.3 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 175,000,000.00 | 135,193,333.50 | 39,806,666.50 | 77.3 |
| Урамшуулал | 200,000,000.00 | - | 200,000,000.00 | 0.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **396,875,000.00** | **154,547,751.55** | 242,327,248.45 | 38.9 |
| Тэтгэврийн даатгал | 269,875,000.00 | 125,411,237.71 | 144,463,762.29 | 46.5 |
| Тэтгэмжийн даатгал | 31,750,000.00 | 8,069,760.17 | 23,680,239.83 | 25.4 |
| ҮОМШӨ-ний даатгал | 25,400,000.00 | 6,323,808.25 | 19,076,191.75 | 24.9 |
| Ажилгүйдлийн даатгал | 6,350,000.00 | 1,303,958.52 | 5,046,041.48 | 20.5 |
| Эрүүл мэндийн даатгал | 63,500,000.00 | 13,438,986.90 | 50,061,013.10 | 21.2 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **647,916,000.00** | **480,613,691.59** | 167,302,308.41 | 74.2 |
| Гэрэл, цахилгаан | 150,000,000.00 | 105,849,665.90 | 44,150,334.10 | 70.6 |
| Түлш, халаалт | 334,524,000.00 | 241,947,959.24 | 92,576,040.76 | 72.3 |
| Цэвэр, бохир ус | 163,392,000.00 | 132,816,066.45 | 30,575,933.55 | 81.3 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **163,000,000.00** | **130,166,545.86** | 32,833,454.14 | 79.9 |
| Бичиг хэрэг | 17,000,000.00 | 10,111,285.00 | 6,888,715.00 | 59.5 |
| Тээвэр, шатахуун | 21,000,000.00 | 21,000,000.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 29,000,000.00 | 25,521,620.86 | 3,478,379.14 | 88.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 46,000,000.00 | 29,017,580.00 | 16,982,420.00 | 63.1 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 50,000,000.00 | 44,516,060.00 | 5,483,940.00 | 89.0 |
| **Нормативд зардал** | **1,230,000,000.00** | **748,245,730.99** | 481,754,269.01 | 60.8 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 680,000,000.00 | 250,268,930.99 | 429,731,069.01 | 36.8 |
| Хоол, хүнс | 550,000,000.00 | 497,976,800.00 | 52,023,200.00 | 90.5 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **138,000,000.00** | **135,022,825.00** | 2,977,175.00 | 97.8 |
| Багаж, техник, хэрэгсэл | 68,000,000.00 | 65,142,700.00 | 2,857,300.00 | 95.8 |
| Урсгал засвар | 70,000,000.00 | 69,880,125.00 | 119,875.00 | 99.8 |
| **Томилолт, зочны зардал** | **1,152,000.00** | **-** | 1,152,000.00 | - |
| Дотоод албан томилолт | 1,152,000.00 | - | 1,152,000.00 | - |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **27,300,000.00** | **13,535,000.00** | 13,765,000.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 2,900,000.00 | - | 2,900,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,600,000.00 | - | 3,600,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,800,000.00 | - | 1,800,000.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,000,000.00 | 12,268,000.00 | (2,268,000.00) | 122.7 |
| Газрын төлбөр | 3,000,000.00 | - | 3,000,000.00 | - |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 4,000,000.00 | 450,000.00 | 3,550,000.00 | 11.3 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,000,000.00 | 817,000.00 | 1,183,000.00 | 40.9 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,200,000.00** | **500,000.00** | 700,000.00 | 41.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | - | 200,000.00 | - |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 500,000.00 | 500,000.00 | 50.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,700,000.00** | **-** | 2,700,000.00 | - |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **2,700,000.00** | **-** | 2,700,000.00 | - |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,700,000.00 | - | 2,700,000.00 | - |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,783,143,000.00** | **3,901,347,739.00** | 1,881,795,261.00 | 67.5 |
| **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **5,561,430,600.00** | **3,814,613,680.00** | 1,746,816,920.00 | 68.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,561,430,600.00 | 3,814,613,680.00 | 1,746,816,920.00 | 68.6 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **221,712,400.00** | **86,734,059.00** | 134,978,341.00 | 39.1 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 137,400,000.00 | 86,734,059.00 | 50,665,941.00 | 63.1 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 84,312,400.00 | - | 84,312,400.00 | - |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1** | **1** | - | 100.0 |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | **1** | - | 100.0 |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 24,212.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрын тайлант оны газрын ногдлыг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаагүй алдааг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 3,000,981.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 966.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 167,964.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2,833,050.0 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

**3.1 Төлбөрийн акт**

Нэр бүхий 2 ажилтны цалингаас 966.0 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар суутган тооцолгүй цалинг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.7-д *"аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

**3.2 Албан шаардлага**

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр бүхий 4 хуулийн этгээдээс худалдан авахдаа 28,987.0 мянган төгрөгийн төлбөрийг татварын цахим И баримтгүй шилжүүлсэн. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",* 13.7 *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Клиник төв байгууллагын сувилал эмчилгээний төвийн барилгын өртөг 2,833,050.0 мянган төгрөгийн давхар бүртгэлтэйг залруулах зөрчилд өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3. *“Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнана."* хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага өгөх

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийг зориулалт, шинж чанараар нь ангилан 326,341.9 мянган төгрөгийг бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* 20 дугаар зүйлийн 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Үндсэн хөрөнгийг зориулалт, шинж чанараар нь зөв ангилан бүртгэх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

__Илрүүлэлт:__ Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн барилга байгууламж 3,277,276.8 мянга, тээврийн хэрэгсэл 55,177.3 мянган төгрөг, нийт 10 нэр төрлийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

__Өгсөн зөвлөмж:__ Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож санхүүгийн тайланд бүртгэх талаар байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг НӨХГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

3. Цалин хөлстэй холбоотой асуудал

__Илрүүлэлт:__ Нэр бүхий зарим албан тушаалтнуудад хууль, журамд заагаагүй “хариуцлагын нэмэгдэл” гэж 137,977.4 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журмын 2-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэсэн заалттай нийцэхгүй байна.

__Өгсөн зөвлөмж:__ Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн нэмэгдэл олгох журмын 2-т заасныг мөрдөж ажиллах

4. Цалин хөлстэй холбоотой асуудал

__Илрүүлэлт:__ Тэтгэврийн насны дээд хязгаарт хүрсэн нэр бүхий 4 ажилтанд цалин олгосон, тэтгэврийн эрх үүсэж төрийн албанаас чөлөөлөгдсөн боловч өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа нэр бүхий ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",* Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т *"Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө",* 46.2.2 "тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн" гэсэн заалтууд, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар зөвлөмжийн 8-д *"Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албаны сонгогддогоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно",* Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3-т *"төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн"* гэсэн заалт, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар зөвлөмжийн 3-т *"Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн албан хаагч төрийн албанд үргэлжлүүлэн ажиллах хүсэлт гаргах болон ажил олгогч ажиллах хугацааг нь сунгах нөхцөлгүй бөгөөд тухайн шийдвэрийг цаг хугацааг нарийн тооцож шийдвэрлэх явдал ажил олгогч албан тушаалтны заавал биелүүлэх үүрэг байна"* гэсэн зөвлөмжтэй тус тус нийцэхгүй байна.

__Өгсөн зөвлөмж:__ Тэтгэврийн насны дээд хязгаарт хүрсэн болон тэтгэврийн эрх үүсэж төрийн албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийг ажиллуулахдаа Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулж ажиллуулах.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрын ногдлыг бүртгэж, тайлагнаагүй | 1 | 24,212.6 | 1 | 24,212.6 | - | - | 1 | 24,212.6 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **24,212.6** | **1** | **24,212.6** | **-** | **-** | **1** | **24,212.6** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 2 ажилтны цалингаас 966,6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцолгүй цалинг илүү олгосон | 1 | 966.7 | 1 | 966.7 | - | - | - | - | - | - | - | - |
| 4 хуулийн этгээдэд 28,987.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээний төлбөрийг и баримтгүй шилжүүлсэн. | 1 | 28,987.0 | - | - | 1 | 28,987.0 | - | - | - | - | - | - |
| Зарим албан тушаалтнуудад Төрийн албаны тухай хууль болон ЗГ-ын 2018 оны 382-р тогтоолоор батлагдсан ТАХ-ийн нэмэгдэл олгох журамд заагаагүй хариуцлагын нэмэгдэл олгосон | 1 | 137,977.4 | - | - | - | - | 1 | 137,977.4 | - | - | - | |
| 326,341.9 мянган төгрөг Үндсэн хөрөнгийг зориулалт, шинж чанараар нь ангилан бүртгээгүй | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Элэгдлээрээ өртгөө нөхсөн барилга байгууламж 3,277,276.85 мянга, тээврийн хэрэгсэл 55,177.3 мянган төгрөг, нийт 10 нэр төрлийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоох талаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлээгүй | 1 | - | | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Тус байгууллагын сувилал эмчилгээний 2,833,050.0 мянган төгрөгийн барилга давхар бүртгэлтэйг залруулах зөрчилд өмнөх аудитуудаар удаа дараа өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй | 1 | 2,833,050.0 | | - | - | - | - | - | 1 | 2,833,050.0 | - | - |
| Тэтгэврийн насны дээд хязгаарт хүрсэн 4 ажилтанд цалин олгосон, тэтгэврийн эрх үүсэж төрийн албанаас чөлөөлөгдсөн боловч өөрийн хүсэлтээр ажиллаж байгаа ажилчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон | - | - | | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| **Дүн** | **7** | **3,000,981.1** | **1** | **966.7** | **1** | **28,987.0** | **4** | **137,977.4** | **1** | **2,833,050.0** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст нийт 5,032,344.6 мянган төгрөгийн 127 мэдээлэл байршуулахаас 490,739.5 мянган төгрөгийн 25 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 490,739.5 | - | - | 1 | 490,739.5 | - | - |
| **Дүн** | **1** | **490,739.5** | **-** | **-** | **1** | **490,739.5** | | |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын байгууллагад ирүүлээгүй, 7 хоног хоцроосон. | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | - | - |
| **Нийт дүн** | **2** | **490,739.5** | **-** | **-** | **2** | **490,739.5** | - | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | - | - | - | - | 1 | - |
| 2 | Төсөл, хөтөлбөр | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | ЗГТС | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | ТТЗ | - | - | - | - | - | - | - | - |
| 5 | ТЕЗ | - | - | - | - | - | - | - | - |
| | **НИЙТ** | **1** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |

**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 22/10810479 Улаанбаатар хот

НТАГ-2024/07/НА-СТА-ТШ

# Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 2 ажилтны цалингаас 966,651.00 (есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун тавин нэг) төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар суутган тооцолгүй цалинг олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3."*Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно*" 6.3.1. "*цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого...*" заалтад заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.3.4-т "*Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй*" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн ажилтнуудад олгосон цалин хөлснөөс суутгаагүй Хувь хүний орлогын албан татварын 966,651.00 (есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун тавин нэг) төгрөгийг холбогдох хүмүүсээс суутган авч Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн захирал Х.Гүрбазар, ерөнхий нягтлан бодогч Л.Байгальмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:**

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — Л.МАЙЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА, — Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР — С.ГАНТӨГС

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002050931

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 07 сарын 23 өдөр Дугаар 03/10810479 Улаанбаатар хот
НТАГ-2024/07/НА-СТА-Тмз

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Клиник төв байгууллагын сувилал эмчилгээний төвийн барилгын өртөг 2,833,050.0 мянган төгрөгийн давхар бүртгэлтэйг залруулах зөрчилд өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3. *"Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнана."* хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн захирал Х.Гүрбазарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга П.Эрхэмбулганд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042521

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 07 сарын 23 өдөр Дугаар 104/10810479 Улаанбаатар хот

НТАГ- 2024/07/ НА-СТА- ТШ

**Сахилгын шийтгэл ногдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 490,739.5 мянган төгрөгийн 25 мэдээллийг байршуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1."Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1.*"мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"*, 4.1.2.*"мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх"*, 4.1.3.*"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т *"Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ."* заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Зөрчил гаргасан ерөнхий нягтлан бодогч Л.Байгалмаа-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиникийн төвийн захирал Х.Гүрбазарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:**

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042693

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 105/10810479 Улаанбаатар хот
НТАГ-2024/07/НА-СТА-ТШ03

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасан хугацаанд санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын байгууллагад ирүүлээгүй, 7 хоног хоцроосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" гэсэн заалтад заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд нь ирүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн захирал Х.Гүрбазар, ерөнхий нягтлан бодогч Л.Байгальмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**[1]**:**

| | |
|---|---|
| АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Л.МАЙЦЭЦЭГ |
| ХЯНАСАН: | |
| САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА | Х.ТҮВШИНБАЯР |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | С.ГАНТӨГС |

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042519

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 06/10810479 Улаанбаатар хот

НТАГ-2024/07/НА-СТА-ТШ

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр бүхий 4 хуулийн этгээдээс худалдан авахдаа 28,987,000.00 *(хорин найман сая есөн зуу наян долоон мянга)* төгрөгийн төлбөрийг татварын цахим И баримтгүй шилжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1."*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7."*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" заалтад заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *“Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.2.1.11-т *“Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа материал, үндсэн хөрөнгийн болон бусад төлбөрийг баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн шилжүүлэх, алдаа зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор гаргаж Нийслэл дэх төрийн аудитын газар-т ирүүлэх;

2.Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн захирал Х.Гүрбазар, ерөнхий нягтлан бодогч Л.Байгальмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:**

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Л.МАЙЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ТҮВШИНБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР С.ГАНТӨГС

1117145633

УХА 612 9077278

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

002042517